


## Монголын сонгогчдын зан үйл: 2013 оны ерөнхийлөгчийн сонгуулийн жишээн дээр

### Abstract

This article shows what has been explained in voting behavior in Mongolia in the case of presidential elections. The results show that strong support for political parties decreased while there is an increase of floating voters, there are significant differences on voter's choice between urban and rural people and support for women candidates is increasing.

**Түлхүүр үг:** Монгол улс, ерөнхийлөгчийн сонгууль, сонгогчдын зан үйл, намын дэмжигчид

Монгол улсын ерөнхийлөгчийн зургаа дахь удаагийн сонгууль 2013 оны 6 сард явагдаж 50.23 хувийн саналаар АН-аас нэр дэвшигч Ц.Элбэгдорж улиран сонгогдсон билээ.



Бүдүүвч 1. 2013 оны ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн авсан санал.


Нийт сонгогчдын 63.89 хувь нь оролцсон энэ удаагийн сонгууль урьд өмнөх сонгуулиудтай харьцуулахад хамгийн бага ирцтэй нь болсон юм. Сонгогчдын ирц яагаад ийм доогуур байв, тэдний санал өгөлтөнд ямар хүчин зүйлс нөлөөлөв, нэр дэвшигч тус бүрийн дэмжигч сонгогч хэн байв зэрэг асуултад хариулт өгөх үүднээс энэхүү өгүүллийг бичлээ.

### Монголын сонгогчдын зан үйлийн ерөнхий хандлага

Анхны ардчилсан сонгуулиас хойшхи 20 гаруй жилийн хугацаанд Монголын сонгогчдын ирц байнга буурч байгаа нь өнгөрсөн жилүүдийн Ерөнхийлөгч, УИХ, орон нутгийн гээд л бүх л сонгуулиудын ирцээс харагдаж байна. Олон нийт улс төрийн үйл явц, намуудын тэмцэл, зөрчлөөс залхаж, сонгогчдын сонгуульд оролцох оролцоо буурч, улс төрөөс хүнийсч байна.

Үүнийг ерөнхийлөгчийн сонгуулиудын жишээн дээр доорх бүдүүвчээр харууля.

## СОНГОГЧДЫН ОРОЛЦОО | 1993-2013



Бүдүүвч 2. Ерөнхийлөгчийн сонгуулиуд сонгогчдын оролцоо

Ийнхүү сонгогчдын ирц буурч байгаа нь улс төрийн намууд мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчдээ сурталчлан таниулахаас гадна өөрийн дэмжигч сонгогчдоо сонгуульд оролцохыг уриалах давхар ажил хийхэд хүргэ.

Монголын сонгогчдын зан үйлийн дараагийн нэг онцлог нь нэг сонгуулиас нөгөө сонгуульд улс төрийн намд өгөх санал өгөлтөө өөрчилдөг хөвдөг сонгогчдын тоо нэмэгдэж байгаа явдал юм. Санал өгөлт нь тогтворгүй байдаг эдгээр сонгогчид нийт сонгогчдын 30 орчим хувийг эзэлж байна, өөрөөр хэлбэр монголчуудын гурван хүн тутмын нэг нь улс төрийн аль ч намыг тогтвортой дэмждэггүй, жил бүрийн сонгуулийн кампанийн ухуулга сурталчилгааны гол өгөөш болж буй бололтой.

Ерөнхий зүй тогтлын хувьд Монголын сонгогчдын улс төрийн намыг дэмжих байдал буурч, харин үүний оронд янз бүрийн том амлалт, элдэв янзын уриа лоозон бүхий популистуудад татагдах явдал нэмэгдэж байгаа юм. 2008, 2012 оны УИХ-ын сонгуулийн кампанийн үеэр бидний хийсэн цуврал судалгаанаас үзэхэд сонгогчдын 25-30 хувь нь санал хураалтын сүүлийн долоо хоног хүртэл саналаа хэнд өгөхөө шийдээгүй эргэлзсээр байдаг нь ажиглагдсан.

Сонгогчдын санал өгөлтөнд ажиглагдаж буй нэгэн шинэ хандлага бол эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих байдал юм. Ялангуяа нийслэлийн иргэдийн дунд эмэгтэй нэр улс төрчдийг дэмжих явдал тогтвортой харагдаж байна. Тухайлбал УИХ-ын 2012 оны сонгуулийн жишээн дээр үзэхэд эмэгтэй нэр дэвшигчийн сонгогдох магадлал эрэгтэй улс төрчийнхөөс даруй 2,5 дахин өндөр байлаа.

## 2013 оны ерөнхийлөгчийн сонгууль дахь сонгогчдын санал өгөлт

### Сонгогчдын оролцоо

2013 оны ерөнхийлөгчийн сонгуульд нийт санал өгөх ёстой нэг сая 900 гаруй сонгогчоос 63.89 хувь буюу 1,223,737 нь оролцов. Өмнөх сонгууль буюу 2009 оныхтой харьцуулахад даруй 10 гаруй хувиар ирц буурчээ. Өмнөх жилүүдийн практикаас харахад жил жилийн сонгуульд нийслэл Улаанбаатарын сонгогчидтой харьцуулахад орон нутгийн сонгогчид илүү идэвхтэй ордог байсан бол энэ удаад байдал эсрэгээр эргэсэн билээ. Нэлээн хэдэн аймагт бороо

орж байсан нь иргэдийн сонгуулийн оролцоонд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн бололтой.

Үүний зэрэгцээ энэ жилийн сонгуулийн хугацаа богино байсны зэрэгцээ сонгуулийн үеийн хэвлэл мэдээлэл, айл өрхөөр тараах ухуулгын материал зэрэг бүхий л сурталчилгаа ихэд хязгаарлалттай явагдсан нь хүмүүсийн сонгуулийн идэвхид нөлөөлсөн байж болох талтай.

Мөн нөгөө талаас сонгуулийн кампани хүмүүсийн сонирхлыг татахуйц үзүүштэй, хурц өрсөлдөөнтэй болоогүй тохиолдолд сонгогчдын ирц буурдаг жамтай.

### **Нутгархах хандлага**

Монгол улс Өрнийн соёлын загвар бүхий суурьшмал амьдралд шилжээд нэгэн зууны нүүрийг үзэж буй хэдий ч амьдралын хэв маяг, олон нийтийн үнэлэмж, хандлагад уламжлалт буюу модерн бус нийгмийн шинж ажиглагдсаар байгаа юм. Үүний нэг илрэл нь сонгогчдын санал өгөлтөнд илэрдэг нутгархах хандлага юм. Өөрийн нутаг уснаас төрийн тэргүүнээ сонгох гэсэн хүсэлтэй хүмүүс бол орон нутгийн сонгогчид билээ. Энэ хандлагыг ерөнхийлөгчийн сонгуулиудын дүнгээс харж болно.

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид өөрийн нутагт хамгийн ямагт сонгогчдын дийлэнх олонхийн санал авч ирсэн байдаг. 1993 онд П.Очирбат төрсөн нутагтаа буюу Завханд сонгогчдын 78.73 хувийн, Л.Түдэв Говь-Алтайд 77.76 хувийн саналыг тус тус авч байжээ. Харин 1997 онд Завханаас гаралтай хоёр нэр дэвшигч өрсөлдсөн тул П.Очирбат, Н.Багабанди нарт тус аймгийн сонгогчдын санал хуваагдаж Н.Багабанди 61.93, П.Очирбат 33.58 хувийн дэмжлэг авч байв.

2013 оны сонгуульд дээрх жишгээр Ховдын сонгогчдын 61.17 хувь, Хэнтий аймгийн 62.5 хувь нь нутгийн хүндээ санал өгчээ.

### **Иргэд эхний санал хураалтаар Ерөнхийлөгчөө тодруулсаар ирэв**

Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд *“нэр дэвшигчдийн хэн нь ч анхан шатны сонгуулийн нэгдсэн дүнгээр олонхын санал аваагүй бол анхны санал хураалтад оролцсон нийт сонгогчийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг хоёр дахь санал хураалтад оруулна”* гэж заасан байдаг ч өнгөрсөн зургаан удаагийн сонгуулийн дүнгээр ямагт эхний санал хураалтаар ялагч тодорч ирсэн билээ.

1993 --- П.ОЧИРБАТ	57.78%
1997 --- Н.БАГАБАНДИ	60.81%
2001 --- Н.БАГАБАНДИ	58.13%
2005 --- Н.ЭНХБАЯР	53.44%
2009 --- Ц.ЭЛБЭГДОРЖ	51.24%
2013 --- Ц.ЭЛБЭГДОРЖ	50.23%

*Бүдүүвч 3. Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан нэр дэвшигчдийн авсан саналын хувь*

1993 оны анхны сонгуульд МАХН-аас Л.Түдэв, П.Очирбат нар өрсөлдсөнөөс П.Очирбат 57.78 хувийн саналаар ялалт байгуулсан юм.

1997 оны сонгуульд МАХН-аас нэр дэвшсэн Н.Багабанди 60.81 хувийн санал авч Ерөнхийлөгчид сонгогдсон нь сонгогчдоос хамгийн өндөр санал авсан нэр дэвшигч болсон юм. П.Очирбат 29.81, Гомбожав 6.64 хувийн саналыг тус тус авсан байна.

2001 оны сонгуульд Н.Багабанди 58.13 хувийн саналаар хоёр дахь удаагаа төрийн тэргүүнд сонгогдсон бол түүний өрсөлдөгч Р.Гончигдорж 36.53, Л.Дашням 3.54 хувийн санал авчээ.

2005 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАХН-ын нэр дэвшигч Н.Энхбаяр 53.44 хувийн саналаар ялалт байгуулсан бол АН-аас нэр дэвшигч М.Энхсайхан 20.03 хувийн санал авсан нь тус намын нэр дэвшигчийн авсан хамгийн бага санал болж байна. Энэхүү сонгуульд анх удаагаа дөрвөн нэр дэвшигч өрсөлдсөн бөгөөд сонгогчдын санал ихээхэн хуваагдаж Б.Жаргалсайхан 13.85, Эрдэнэбат 11.33 хувийн санал авав.

2009 оны сонгуульд МАХН-аас тухайн үеийн Ерөнхийлөгч Н.Энхбаяр, АН-аас Ерөнхий сайд асан Ц.Элбэгдорж нар нэр дэвшиж сонгогчдын 51.24% нь АН-ын Элбэгдоржийг, 47.44% нь МАХН-ын Энхбаярыг дэмжиж санал өгчээ.

2013 онд Ц.Элбэгдорж 50.23 хувийн, Б.Бат-Эрдэнэ 41.97 хувийн, Н.Удвал 6.5 хувийн санал авав. Энэхүү дүнгээс үзэхэд Ц.Элбэгдорж хамгийн бага санал авч сонгогдсон Ерөнхийлөгч болж байгаа юм.


### МАН-ын гол дэмжигч аймгууд

Хүн амын суурьшил, хэвлэл мэдээллийн хүртээмж, соёл, амьдралын хэв маяг зэрэг олон үзүүлэлтээр хотын ба хөдөөгийн иргэдийн дунд ялгаа байсаар байна. Нийгэм, соёлын энэхүү ялгаа нь сонгогчдын улс төрийн зан үйлд илэрч намыг дэмжих байдалд нөлөөлдөг нь сонгуулийн дүнгээс тодорхой харагдаж зарим бүс нутаг, аймагт зөвхөн нэг нам л тогтвортой дэмжлэг хүлээж ирсэн байх юм.

Ерөнхийлөгчийн сонгуулиудын дүнгээс харахад 1993 онд Баян-Өлгий, Дундговь, Увс, Ховд, 1997 онд Говь-Алтай, Дундговь, Өмнөговь, Увс, Ховд аймгууд, 2005 онд Говь-Алтай, Сүхбаатар, Увс аймгийн сонгогчдын 60-аас дээш хувь нь нэр дэвшигч Н.Энхбаярт саналаа өгч байв.

Харин 2009 онд Н.Энхбаяр Говьсүмбэр, Сүхбаатар аймагт 60-аас дээш хувийн санал авч байсан юм.

2013 онд Сүхбаатар 54.49, Дундговь 53,8, Дорноговь 53.3 хувиар тус тус Б.Бат-Эрдэнийг дэмжигч гол аймгууд боллоо.



Бүдүүвч 4. 2013 оны ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Ц.Элбэгдорж, Б.Бат-Эрдэнэ нарын авсан саналыг аймгуудаар харуулсан байдал

### АН-д ээлтэй аймгууд

Нэр дэвшигчийн төрсөн аймгийг эс тооцон бусад аймгуудын сонгуулийн дүнгээс харахад 1993 онд Хэнтий, Архангай, Баянхонгор, 1997 онд Архангай, Дорнод, Хөвсгөл, Хэнтий аймгууд АН-аас нэр дэвшигч П.Очирбатын төлөө Улаанбаатарын сонгогчдоос ч илүү өндөр санал өгсөн байна.

Мөн 2001 онд Архангай, Баянхонгор, Өвөрхангай, Хөвсгөл, Хэнтий, 2005 онд Дорнод, Хөвсгөл, 2009 онд Архангай, Дорнод, Хөвсгөл аймгийн сонгогчдын олонх АН-аас нэр дэвшигчдийн төлөө саналаа өгч иржээ.


Эндээс үзвэл Дорнод, Хөвсгөл аймгуудын сонгогчдын олонх АН-аас нэр дэвшигчид саналаа өгч ирсэн уламжлалтай байна. Ц.Элбэгдоржид саналаа өгөх магадлалтай. Мөн хамгийн сүүлийн сонгууль буюу орон нутгийн сонгуульд АН олонх болсон Сүхбаатар аймгаас бусад аймгууд болох Баян-Өлгий, Өмнөговь аймгийн сонгогчдын олонх АН-ын нэр дэвшигчид саналаа өгчээ.

### АН-ыг анхнаас нь дэмжигчид бол хотынхон

Өнгөрсөн сонгуулиудын түүхээс харахад бүр анхнаасаа л нийслэл Улаанбаатар болон Эрдэнэт, Дарханы сонгогчид АН-аас нэр дэвшигчдийн гол дэмжлэг болж ирсэн байдаг. Тухайлбал, 2009 оны Ерөнхийлөгчийн сонгуульд аймгуудын нэгдсэн дүнгээр 50.25 хувийн санал авсан Н.Энхбаяр хөдөөд ялалт

байгуулсан бол Ц.Элбэгдорж нийслэлийн сонгогчдын 55.59 хувийн саналыг авсны хүчинд нийт дүнгээр тэргүүлсэн юм.

2013 оны Ерөнхийлөгчийн сонгуульд Ц.Элбэгдоржийн найдвартай ар тал болох нийслэлчүүдийн 54.47 хувь нь түүнд, 38.8 хувь нь Б.Бат-Эрдэнэд, 5.75 хувь нь Н.Удвалд саналаа өгсөн бол хөдөөд Ц.Элбэгдоржийн төлөө 46.61, Б.Бат-Эрдэнэд 44.68, Н.Удвалд 7.1 хувь нь саналаа өгчээ.



Бүдүүвч 5. 2013 оны ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Ц.Элбэгдорж, Б.Бат-Эрдэнэ нарын авсан саналыг нийслэл ба орон нутгаар харьцуулсан байдал

### Ц.Элбэгдоржийг ялахад нөлөөлсөн сонгогчид

Ц.Элбэгдорж Б.Бат-Эрдэнээс 102 414 сонгогчийн санал илүү авч ялалт байгуулсан. Ц.Элбэгдоржийг ялахад гол нөлөө үзүүлсэн сонгогчид бол нийслэлийн сонгогчид юм. Нийслэлд Ц.Элбэгдорж 87936 мянган сонгогчоор илүү байгаа юм.

Үүний дараа нэр дэвшигчийн төрсөн нутаг Ховд аймгийг эс тооцвол Хөвсгөл, Орхон, Баян-Өлгий, Дорнод, аймгийн сонгогчид орж байна. Хөвсгөлд Бат-Эрдэнээс 6229 сонгогчоор илүү санал авчээ. Орхонд 5810, Баян-Өлгийд 5542, Дорнодод 4300 сонгогчоор тус тус илүү гарчээ.

Ийнхүү Монголын сонгогчдын зан үйлийг ерөнхийлөгчийн сонгуулийн жишээн дээрээс авч үзэхэд сонгогчдын оролцоо буурах, хөвдөг сонгогчдын тоо нэмэгдэх хандлага гүнзгийрч байгаагийн зэрэгцээ хүн амын нягтшил, хэвлэл мэдээллийн хүртээмж, соёлын ялгаагаар нөхцөлдсөн хот, хөдөөгийн амьдралын ялгаатай хэв маяг нь намыг дэмжих байдалд хүчтэй нөлөөлдөг нь харагдаж байна.